



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/03-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Сүхбаатар сум

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: О.Анхбаяр

Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө	12
3.5.2 Авлага	12
3.5.3 Бараа материал.....	13
3.5.4 Үндсэн хөрөнгө.....	14
3.5.5 Өр төлбөр.....	15
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо	15
3.5.7 Орлогын данс.....	16
3.5.8 Зардлын данс.....	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	21
3.8 Аудитын гол асуудал	21
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	22
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	23
4. Аудитын илрүүлэлт	24
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	28

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТҮ	Төрийн үйлчилгээ
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХАА	Хүнс хөдөө аж ахуй
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



БЯАНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Р.БАТЖАРГАЛ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.25 № СЭА 2022/03-НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	949,863.34	1,712,824.38
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	286,229.08	975,137.85
33	АВЛАГА	324,529.66	402,598.34
35	БАРАА МАТЕРИАЛ	339,104.60	335,088.19
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,049,986.99	10,341,055.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,049,986.99	10,341,055.04
39200	Биет хөрөнгө	6,842,667.62	10,135,154.42
39300	Биет бус хөрөнгө	207,319.37	205,900.62
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,999,850.33	12,053,879.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	46,591.99	48,388.36
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	46,591.99	48,388.36
41300	Өглөг	46,591.99	48,388.36
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,953,258.34	12,005,491.06
51	Засгийн газрын хувь оролцоо	7,953,258.34	12,005,491.06
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,583,632.43	2,583,632.43
51200	Хуримтлагдсан үр дүн	1,676,243.83	5,728,476.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,693,382.09	3,693,382.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,999,850.33	12,053,879.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,505,781.45	8,357,768.64
11	ТАТВАРЫН ОРЛОГО	113,597.90	447,504.96
110	Орлогын албан татвар	68,403.68	98,218.05
1100	Хувь хүний орлогын албан татвар	68,403.68	98,218.05
113	Хөрөнгийн албан татвар	1,804.00	234,581.37
118	Бусад татвар, төлбөр, хураамж	43,390.22	114,705.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,043,925.31	4,093,684.23
120	Нийтлэг татварын бус орлого	1,043,925.31	4,093,684.23
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,348,258.23	3,816,579.45
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,950,625.94	4,305,285.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,950,625.94	4,305,285.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,681,050.56	4,057,789.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,111,781.68	2,150,709.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	260,509.58	282,830.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	345,945.35	345,429.48
2104	Хангамж, бараа материалын зардал	91,934.63	98,021.04
2105	Нормативт зардал	191,379.13	381,446.43
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,229.35	56,812.91
2107	Томилолт, зочны зардал	3,654.52	4,292.70

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,559.35	44,872.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	602,056.96	693,373.85
212	ТАТААС	80,784.30	93,766.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	188,791.08	153,729.23
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	555,155.51	4,052,483.48
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	49,993.16	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	505,162.35	4,052,483.48

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,451,921.47	0.00	7,451,921.47
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,825.48)	0.00	(3,825.48)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,448,095.99	0.00	7,448,095.99
9	Тайлант үеийн үр дүн	505,162.35	0.00	505,162.35
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,953,258.34	0.00	7,953,258.34
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,953,258.34	0.00	7,953,258.34
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,953,258.34	0.00	7,953,258.34
19	Тайлант үеийн үр дүн	4,052,483.48	0.00	4,052,483.48
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	12,005,491.06	0.00	12,005,491.06

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,758,512.07	4,499,941.39
11	ТАТВАРЫН ОРЛОГО	113,597.90	447,504.96
110	Орлогын албан татвар	68,403.68	98,218.05
1100	Хувь хүний орлогын албан татвар	68,403.68	98,218.05
113	Хөрөнгийн албан татвар	1,804.00	234,581.37
118	Бусад татвар, төлбөр, хураамж	43,390.22	114,705.54
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	15,333.27	19,755.40
1181	Газрын төлбөр	16,777.05	61,385.96
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	11,279.90	33,564.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	237,987.93	426,993.52
120	Нийтлэг татварын бус орлого	237,987.93	426,993.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,348,258.23	3,625,442.91
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,446,025.82	3,596,222.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,446,025.82	3,596,222.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,177,304.94	3,348,826.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,106,413.49	2,147,429.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	265,685.25	282,616.70

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	345,945.35	345,608.68
2104	Хангамж, бараа материалын зардал	78,576.68	89,803.56
2105	Нормативт зардал	199,764.74	301,971.89
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,197.14	22,696.24
2107	Томилолт, зочны зардал	3,662.20	4,292.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,013.43	46,975.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,988.65	107,433.05
212	ТАТААС	80,784.30	93,766.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	187,936.58	153,629.23
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	253,818.25	903,719.17
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	245,216.18	156,810.41
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	245,216.18	156,810.41
2200	Дотоод эх үүсвэрээр	245,216.18	156,810.41
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(245,216.18)	(156,810.41)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(140,000.00)	(58,000.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	140,000.00	58,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(131,397.94)	688,908.77
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	417,627.02	286,229.08
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	286,229.08	975,137.85

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт / хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,734,623.00	3,377,580.34	(357,042.66)	90.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,414,200.70	3,229,747.84	(184,452.86)	94.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,258,330.20	3,081,261.61	(177,068.59)	94.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,198,857.60	2,118,454.32	(80,403.28)	96.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	301,024.90	278,822.37	(22,202.53)	92.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	354,916.20	345,570.13	(9,346.07)	97.37
2104	Хангамж, бараа материалын зардал	67,371.00	64,887.56	(2,483.44)	96.31
2105	Нормативт зардал	147,144.60	119,925.16	(27,219.44)	81.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	62,722.10	54,778.84	(7,943.26)	87.34
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,287.60	16,902.94	(6,384.66)	72.58
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,617.30	77,807.58	(17,809.72)	81.37
212	ТАТААС	93,766.00	93,766.00	0.00	100.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	93,766.00	93,766.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,104.50	54,720.23	(7,384.27)	88.11

2132	Бусад урсгал шилжүүлэг	62,104.50	54,720.23	(7,384.27)	88.11
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	262,422.30	89,832.51	(172,589.79)	34.23
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	58,000.00	58,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,734,623.00	3,646,596.38	(88,026.62)	97.64
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,283,483.40	2,212,712.40	(70,771.00)	96.90
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,323,736.40	1,256,349.24	(67,387.16)	94.91
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	56,383.20	20,049.41	(36,333.79)	35.56
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	71,020.00	157,485.33	86,465.33	221.75
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	158,104.02	158,104.02	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	427,120.05	427,120.05	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,796.00	6,036.00	4,240.00	336.08
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	10.00	10.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	178.00	173.00	(5.00)	97.19
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,430.00	1,426.00	(4.00)	99.72
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,060.00	1,009.00	(51.00)	95.19
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	370.00	417.00	47.00	112.70
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	0.00	0.00	0.00	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	0.00	4,254.00	4,254.00	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	178.00	173.00	(5.00)	97.19

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	389,119.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	389,119.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	334,543.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,974.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,794.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38.55
2104	Хангамж, бараа материалын зардал	25,425.99
2105	Нормативт зардал	182,046.72
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,335.30
2107	Томилолт, зочны зардал	180.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,072.16
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,675.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,576.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,078.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,498.48
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	394,975.46
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	394,975.46

III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	5,855.70
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,855.70

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид Баянгол сумын ТТЗ гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримт, төлбөрийн цахим баримттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянгол сумын ТТЗ нь 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дүгээр сарын 03-ний өдрийн 02/37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянгол сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Иргэдийнхээ орон нутагтаа ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэх, сумынхаа эдийн засаг нийгмийн хөгжлийг тогтвортой өсгөх, хүний хөгжлийг эрхэмлэн дээдлэх” гэж тодорхойлсон байна.

Баянгол сумын ТТЗ нь тайлант онд дараах үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны

журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,

- Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- Аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт.

Баянгол сумын ТТЗ-аас хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

Тус ТТЗ-ын харьяа төсөвт байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бөгөөд тус төвлөрүүлэн захирагчийн багцад хамаарах “Баянгол сувилал” ААТҮГ нь холбогдох “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөөгүй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянгол сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг **2.0** хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,950,625.9 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 79,012.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу **63,210.0** мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 286,229.1 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 975,137.8 мянган төгрөг болж, 688,908.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
			Өсөлт/+, бууралт/-	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	286,229.1	975,137.8	688,908.7	70.6
Дүн	286,229.1	975,137.8	688,908.7	70.6

Эх сурвалж: Баянгол сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан 975,137.8 мянган төгрөг орон нутгийн ерөнхий орлогын дансанд 492,413.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд 26,438.5 мянган төгрөг, ОНХС-ийн дансанд 274,188.9 мянган төгрөг, барьцаа хөрөнгийн дансанд 23,310.6 мянган төгрөг, СХС-ийн дансанд 148,673.8 мянган төгрөг, ЭМТ-ийн дансанд 10,113.0 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 301,560.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 402,598.3 мянган төгрөг болж, 101,037.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
			Өсөлт/+, бууралт/-	
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.0	193,541.3	193,541.3	
Татаас, санхүүжилтийн авлага	2,404.8		(2,404.8)	
Зээлийн хүүгийн авлага	14,488.3	6,343.5	(8,144.8)	
Байгууллагаас авах авлага	214.1		(214.1)	
Хувь хүмүүст олгосон зээл	284,453.6	202,713.5	(81,740.1)	
Дүн	301,560.8	402,598.3	101,037.5	

Эх сурвалж: Баянгол сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 99,207.7 мянган төгрөгийн авлага байгаагаас СХС-ийн 2011-2018 онуудад олгосон эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн 92,864.3 мянган төгрөгийн болон зээлийн хүүгийн авлагын 6,343.5 мянган төгрөгийн авлагууд бүртгэлтэй байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдэлд СХС-ийн зээл, хүүгийн авлагын 209,057.0 мянган төгрөг, ЭМТ-ийн ЭМДС-аас авах санхүүжилтийн 193,541.3 мянган төгрөг байна.

Тайлант онд хугацаа хэтрүүлсэн зээлийн СХС-ийн зээлийн 185,820.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар 12 иргэнд албан мэдэгдэл өгч, биечлэн уулзах, утсаар холбогдон 89,220.2 мянган төгрөгийн зээл, хүүгийн авлагыг барагдуулж ажилласан байна. СХС-ийн зээлдэгчдийн зээлийн мэдээллийг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс Монголбанкны зээлийн мэдээллийн санд оруулсан байна.

3.5.3 Бараа материал

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт/-
Тусгай зориулалттай материал	1,014.0	2,390.0	1,376.0
Эм боох материал	19,667.3	11,520.5	(8,146.8)
Дуусаагүй үйлдвэрлэл	18,000.0	18,000.0	-
Бэлэн бүтээгдэхүүн	35,226.2	30,535.7	(4,690.5)
Бичиг хэргийн материал	5,538.8	5,308.4	(230.4)
Аж ахуйн материал	6,135.7	6,773.1	637.4
Сэлбэг хэрэгсэл	1,280.0	-	(1,280.0)
Түлш, шатах тослох материал	3,000.0	23.9	(2,976.1)
Хүнсний материал	5,276.7	5,573.2	296.5
Бусад хангамжийн материал	243,965.9	254,963.3	10,997.4
Дүн	339,104.6	335,088.2	(4,016.4)

Эх сурвалж: Баянгол сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл (4,016.4) мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 623,058.1 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, хандив, тусламжаар 86,763.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан, данснаас дансанд 6,934.0 мянган төгрөгийг шилжүүлсэн зэргээр нийт 716,755.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 630,855.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 89,832.5 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн, 84.5 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассанаас шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

ЕБС:

- **210,846.4** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Цэцэрлэг:

- **4,120.5** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

ИТХ:

- **18,811.4** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

ЗДТГ:

- **5,140.2** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Соёлын төв:

- **1,592.2** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

ЭМТ:

- **132,127.2** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл /анхны өртгөөр/ 8,744,364.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 12,598,856.7 мянган төгрөг болж 3,854,491.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	<i>/мянган төгрөг/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт/-
Барилга, байгууламж, орон сууц	5,581,570.1	8,826,973.3	3,245,403.2
Хуримтлагдсан элэгдэл	(538,856.0)	(838,381.9)	(299,525.9)
Авто-тээврийн хэрэгсэл	336,060.5	339,110.5	3,050.0
Хуримтлагдсан элэгдэл	(132,256.6)	(183,096.0)	(50,839.4)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	957,873.9	1,065,906.3	108,032.4
Хуримтлагдсан элэгдэл	(568,745.6)	(650,574.1)	(81,828.5)
Тавилга, аж ахуйн эд хогшил	538,245.9	591,678.1	53,432.2
Хуримтлагдсан элэгдэл	(199,111.0)	(230,039.7)	(30,928.7)
Зам, гүүрийн байгууламж	951,408.2	951,408.2	-
Хуримтлагдсан элэгдэл	(229,868.7)	(316,232.9)	(86,364.2)
Бусад үндсэн хөрөнгө	91,966.1	531,164.4	439,198.3
Хуримтлагдсан элэгдэл	(23,674.4)	(36,192.7)	(12,518.3)
Ном	78,055.3	83,430.9	5,375.6
Программ хангамж	8,300.0	8,300.0	-
Хуримтлагдсан элэгдэл	(1,865.6)	(3,284.4)	(1,418.8)
Бусад биет бус хөрөнгө	200,885.0	200,885.0	-
Дүн	7,049,987.1	10,341,055.0	3,291,067.9

Эх сурвалж: Баянгол сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө данс нь 3,854,491.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 66,977.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив, тусламжаар 97,163.8 мянган төгрөг, үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, данснаас дансанд 3,714,545.8 мянган төгрөгийг шилжүүлэн авсан зэрэг 3,878,687.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, акталж устгасан 24,195.7 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

ЭМТ:

- Үндсэн хөрөнгөд **13,283.1** мянган төгрөгийн элэгдэл зөрүүтэй тайлагнасан,
- Тус байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 2019-2020 онуудад орлого авсан 60 нэр төрлийн үндсэн хөрөнгөд элэгдэл тооцож зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэж, тайлагнаагүй байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 46,592.0 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 48,388.4 мянган төгрөг болж, 1,796.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
			Өсөлт/+, бууралт/-	Дүнд эзлэх хувь
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	23,929.6	23,929.6	100.0
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	414.4	-	(414.4)	(100.0)
Байгууллагад төлөх өглөг	22,060.6	23,310.6	1,250.0	5.4
Хувь хүмүүст төлөх өглөг	1,148.2	1,148.2	-	-
Дүн	23,623.2	48,388.4	24,765.2	51.2

Эх сурвалж: Баянгол сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 48,388.4 мянган төгрөг болж 24,765.2 мянган төгрөгөөр өссөн нь ЭМДС-ийн 11,12-р сарын санхүүжилт орж ирээгүйгээс ЭМТ-д 23,929.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн өглөг үүссэн, байгаль хамгаалах сангийн барьцаа хөрөнгийн өглөг 1,250.0 мянган төгрөгөөр өссөн, СХС-тай холбоотой татаас санхүүжилтийн өглөг 414.4 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,953,258.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 11,992,208.0 мянган төгрөг болж, 4,040,746.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
			Өсөлт/+, бууралт/-	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,583,632.4	2,583,632.4	-	-

Хуримтлагдсан үр дүн	1,676,243.8	5,715,193.5	4,038,949.7	70.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,693,382.1	3,693,382.1	-	-
Дүн	7,953,258.3	11,992,208.0	4,038,949.7	70.7

Эх сурвалж: Баянгол сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь 3,245,403.2 мянган төгрөгийн Соёлын төвийн барилга хүлээн авсан, 344,940.3 мянган төгрөгийн үнэ бүхий тариалангийн талбайн хашааг хөрөнгөд бүртгэснээс голлон шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд сумын ЗДТГ-т журмын хашааны 1,952.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

“Баянгол сувилал” ААТҮГ:

- Тайлант онд банкин дахь дансанд 19,107.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн боловч санхүүгийн санхүүгийн тайланд 12,897.7 мянган төгрөгөөр буюу **6,210.0** мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

3.5.8 Зардлын данс

Аудитын илрүүлэлт:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал:

- Төсвийн санхүүжилтийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс үндсэн цалингаас БИНХ-ын урамшууллын зардалд **797.1** мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан,

Засаг даргын тамгын газар:

- Төсвийн санхүүжилтийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс үндсэн үйл ажиллагааны НДШ-ийн зардлаас баг хорооны НДШ-ийн зардалд **1,165.7** мянган төгрөг ийг гүйлгэн зарцуулсан.

Эрүүл мэндийн төв:

- Төсвийн санхүүжилтийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс НДШ-ийн зардлаас цалингийн зардалд **4,910.0** мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан.

“Баянгол сувилал” ААТҮГ:

- Тайлант онд банкин дахь дансаар 18,799.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн боловч 2021 оны санхүүгийн тайланд 12,589.3 мянган төгрөгөөр буюу **6,210.0** мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Баянгол сумын ИТХ-ын “Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 2021 оны 32 дугаар тогтоолоор тайлант онд 97,629.0 мянган төгрөгийн татварын орлого, 154,779.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт 252,408.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 716,121.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 183.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №7 Төвлөрүүлэх орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
			Зөрүү	Биелэлтийн хувь
Хувь хүний орлогын албан татвар	35,000.0	56,373.1	21,373.1	161.1
Хөрөнгийн орлого	3,500.0	19,282.4	15,782.4	550.9
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	3,000.0	22,562.5	19,562.5	752.1
Бууны албан татвар	1,558.0	1,678.0	120.0	107.7
Малд ногдуулах албан татвар	0.0	232,903.4	232,903.4	
Улсын тэмдэгтийн хураамж	5,250.0	5,274.7	24.6	100.5
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	795.0	795.0		100.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	13,500.0	13,685.8	185.8	101.4
Газрын төлбөр	20,000.0	56,855.3	36,855.3	284.3
Газрын дуудлага худалдаа	4,530.0	4,530.6	0.6	100.0
Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр	456.0	2,355.8	1,899.8	516.6
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	40.0	40.0		100.0
Байгалийн ургамал ашигласны төлбөр	10,000.0	31,168.4	21,168.4	311.7
Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого	114,779.0	219,086.3	104,307.3	190.9
Хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого	40,000.0	49,530.6	9,530.6	123.8
Дүн	252,408.0	716,121.9	463,713.9	283.7

Эх сурвалж: Баянгол сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд ХХОАТ-ын орлого 21,373.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн орлого 15,782.4 мянган төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 19,562.5 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 36,855.3 мянган төгрөгөөр, хүү, торгуулийн орлого 104,307.3 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн болон төлөвлөөгүй байсан малын хөлийн албан татвар 232,903.4 мянган төгрөгийг төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- Хувь хүний орлогын албан татвар 21,373.1 мянган төгрөгөөр давж биелсэн нь хувиараа ашигт малтмал олборлогч 4 иргэнээс ХХОАТ-ын тайлан гаргуулж урьдчилгаа татвар төлүүлсэн,
- Хөрөнгийн орлого 15,782.4 мянган төгрөгөөр давж биелсэн нь Төрийн банкнаас хадгаламжийн хүүгийн орлогыг суманд төвлөрүүлсэн,
- Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 19,562.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь өмнөх оныхтой харьцуулахад иргэдийн шилжилт хөдөлгөөн ихсэж, газар, үл хөдлөх хөрөнгө борлуулсан иргэдийн тоо нэмэгдсэн,
- Малын хөлийн албан татвар 232,903.4 мянган төгрөг төвлөрүүлсэн нь 2021 оноос шинээр авч эхэлсэн бөгөөд төсөвт тусгаагүй,
- Газрын төлбөр 36,855.3 мянган төгрөгөөр давж биелсэн нь газрын цахим бүртгэл нэвтэрсэнтэй холбоотойгоор иргэдийн эзэмшил, өмчлөлийн газрын төлбөрийг иргэн бүрд ноогдуулсан,
- Хүү, торгуулийн орлого 104,307.3 мянган төгрөгөөр давж биелсэн нь төрөөс 10 дугаар сарын 31-нээс өмнө торгуулийн 50 хувиа төлсөн иргэдийн үлдсэн 50 хувийг хөнгөлөх болсноор торгуулийн төлөлт нэмэгдсэн зэргээс голлон шалтгаалсан байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг 2,112,559.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өргөн барьсан төсвийн төслийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 10 дугаар тогтоолоор нийт зарлагыг 3,720,594.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын төсөвт хийгдсэн нийт 1 удаагийн тодотгол болон зохицуулалтаар дараах өөрчлөлтүүд орж сумын төсөв **3,669,090.0** мянган төгрөгөөр эцэслэн батлагдсан байна. Үүнд:

ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар тогтоол:

- Сумын татварын орлогын төлөвлөгөөг 2,750.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон,
- ИТХ-ын тэтгэмж урамшууллын зардлыг 2,750.0 мянган төгрөгөөр,
- ЗДТГ-ын үндсэн үйл ажиллагааны зардлыг 3,403.3 мянган төгрөг, тохижилтын зардлыг 2,000.0 мянган төгрөгөөр,
- Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлын санхүүжилтийг 10,485.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн,
- Спорт цогцолбор нь аймгийн төсвөөс санхүүждэг болсноор санхүүжилтийг 59,254.6 мянган төгрөгөөр бууруулж, эрүүл мэндийн төвийн барилга, тээврийн хэрэгслийн урсгал засварын зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн зэргээр аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 54,254.6 мянган төгрөгөөр бууруулсан.
- Ерөнхий боловсролын сургуулийн тогтмол зардлыг 4,818.5 мянган төгрөгөөр,

- Хүүхдийн цэцэрлэгийн тогтмол зардлыг 6,070.3 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрт зориулан **3,669,090.0** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,348,667.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 262,422.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 58,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар тогтоожээ.

Нийт зардлын 2,217,950.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 691,930.4 мянган төгрөгийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгээс, 252,408.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 121,675.2 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 56,383.2 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 5,000.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 257,722.3 мянган төгрөгийг ОНХС-аас, 4,700.0 мянган төгрөгийг ОНХС-ын урьд оны үлдэгдлээс, 61,320.0 мянган төгрөгийг СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 2,283,483.4 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэг 691,930.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 716,121.9 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 20,049.4 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1,952.0 мянган төгрөг, ОНХС-аас 257,722.3 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 155,533.3 мянган төгрөг зэрэг нийт **4,126,792.7** мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **3,377,580.3** мянган төгрөг буюу 92.6 хувьтай тайлагнагдсан нь эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 102,605.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 9,346.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 2.483.4 мянган төгрөгөөр, нормативт зардал 27,219.4 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 7,777.3 мянган төгрөгөөр, албан томилолтын зардал 3,276.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 6,384.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 17,809.7 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 7,384.3 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 172,589.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 2 төсөл, арга хэмжээнд 262,422.3 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 89,832.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 274,188.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчид бус этгээдээс авсан хандив, тусламж 33,537.6 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчдаас 78,630.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 190,047.6 мянган төгрөг, ЭМДС-ийн нэмэлт орлого 92,759.8 мянган төгрөг зэрэг нийт 394,975.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж:

- Тайхаржин майнинг ХХК-иас 5,000.0 мянган төгрөг,
- Пентатерра ХХК-иас 5,000.0 мянган төгрөг,
- Иргэдээс 23,537.6 мянган төгрөг зэрэг нийт 33,537.6 мянган төгрөгийг Ковид-19 өвчинтэй холбоотойгоор Сумын Онцгой Комиссын үйл ажиллагаанд хандивласан байна.

Дээд шатны төсвийн захирагчдаас:

- Аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллого, судалгааны зардалд 1,977.8 мянган төгрөг,
- ХХАА-н газраас ургац хураалтын дүн мэдээ нэгтгэх шатахууны зардалд 200.0 мянган төгрөг,
- ГБХЗХГ-аас эрүүл гэр бүл сэдэвт сургалтын зардалд 150.0 мянган төгрөг
- Мал эмнэлгийн газраас малын гоц халдварт шүлхий өвчний шатахууны зардалд 1,000.0 мянган төгрөг
- Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас замын сангийн 32,500.0 мянган төгрөг,
- Онцгой байдлын газраас ой хээрийн түймрийн хяналтын постын өглөг барагдуулах 2,404.8 мянган төгрөг,
- Сумын ЭМТ-д аймгийн ЭМГ-аас 1 удаагийн буцалтгүй тусламж, шатахуун, томилолтын зардал зэрэгт 28,292.8 мянган төгрөг,
- Боловсролын газраас ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд сургуульд 952.0 мянган төгрөг, цэцэрлэгт 253.0 мянган төгрөг, хөтөлбөрийн санхүүжилтэд сургуульд 10,600.0 мянган төгрөг,
- Аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд ИТХ-д 300.0 мянган төгрөг зэргийг тус тус шилжүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд:

- ЗДТГ нь цэвэр бохир усны төрөөс хариуцах төлбөрийн 13,500.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлийн орлого 8,336.8 мянган төгрөг, Сангийн яамны зам засварын санхүүжилт 9,000.0 мянган төгрөг, будааны үнэ 664.5 мянган төгрөг, түрээсийн төлбөр 275.0 мянган төгрөг, тендерийн хураамж 105.0 мянган төгрөг, захиалагчийн хяналтын зардал 306.0 мянган төгрөг, , гарал үүслийн үнэ 97.5 мянган төгрөг, гоожингийн хуудасны үнийн 33.0 мянган төгрөг,
- Цэцэрлэг нь цахим тендерийн хураамж 105.0 мянган төгрөг,

- ЭМТ нь Эмийн болон оношлуурын орлогын 157,564.7 мянган төгрөг,
- Соёлын төв нь урьд оны татан төвлөрүүлэлтийн 60.0 мянган төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлэн ажилласан байна.

Үүнээс цалин, НДШ-ийн зардалд 32,769.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 38.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 25,426.0 мянган төгрөг, нормативт зардалд 182,046.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 29,335.3 мянган төгрөг, томилолтын зардалд 180.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 32,072.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 32,675.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулалд 28,078.0 мянган төгрөг тус тус зарцуулж, 26,498.5 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

- Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 3.1-д *“Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно”* 3.1.2. *“Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албан хаагч болсон иргэний 1990 оны 3 дугаар сарын 23-наас өмнө нам, олон нийтийн төв, орон нутгийн байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан хугацаа”* гэж зохицуулсан байдаг.

Гэтэл өндөр насны тэтгэвэр тогтоолгосон жижүүр Б.Доржпүрэвт Баруунхараагийн сангийн аж ахуйд ажилласан 16 жилийн хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож, буцалтгүй тусламж олгохоор ирүүлсний дагуу нийт 10,780.1 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ нь Баруунхараагийн сангийн аж ахуй нь орон нутгийн байгууллага мөн эсэх талаарх эрсдэл үүсгэж байгаа учир төрийн албанд ажилласан хугацааг үнэн зөв тодорхойлж, тэтгэмж олгох нь зүйтэй гэж үзэж байна.

- ЭМТ нь ЭМДЕГ-аас авах 11,12-р сарын Ковидын санхүүжилт болох 193,541.3 мянган төгрөгийн дутуугаас шалтгаалан 23,929.6 мянган төгрөгийн эмийн өглөг үүссэн байна.

3.8 Аудитын гол асуудал

- Сумын онцгой комисс нь Ковид-19 цар тахалтай тэмцэхэд зориулж иргэд, аж ахуйн нэгжээс хандивласан 33,537.6 мянган төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт №8 ТТЗ-ийн харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл

Үзүүлэлт	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
Засаг дарга	155	93	62	
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	151	142	4	5
Засаг даргын тамгын газар	151	140	3	8
Эрүүл мэндийн төв	151	131	15	5
Соёлын төв	151	99	41	11
Дүн	759	605	125	29

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 759 мэдээллээс 605 мэдээллийг хугацаанд нь, **125** мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол огт мэдээлээгүй **29** мэдээлэл байна.

“Баянгол сувилал” ААТҮГ нь шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цахим хаяг нээлгээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх “Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна. 3.1.1: Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” 7.1 дэх “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”, 7.1.3: Тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цахим хаяг нээлгэж, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

1. Баянгол сумын ТТЗ-ийн тайлант оны үйл ажиллагаанд 3,669,090.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 3,377,580.3 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 7.4 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт:

- ИТХ нь тайлант оны үйл ажиллагаанд 82,649.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 78,804.8 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 4.7 хувиар хэмнэсэн,
- ЗДТГ нь тайлант оны үйл ажиллагаанд 624,230.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 575,875.6 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 7.7 хувиар хэмнэсэн,

2. ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т: “.....бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэж заасныг дараах байгууллагууд зөрчсөн байна. Үүнд:

- ИТХ нь 500.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил,
- ЗДТГ нь 2,500.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, зэргийг худалдан авсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 17,045.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага, 62,048.2 мянган төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 9. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	7	17,045.6	7	17,045.6	100.0
Зөвлөмж	5	62,048.2	4	62,048.2	80.0
Нийт дүн	12	79,829.2	11	79,829.2	91.6

Өмнөх оны аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг Улс, орон нутгийн төсвийн

хөрөнгө оруулалтын үр дүн, ОНХС-ийн зарцуулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 6, орон нутгийн төсөл сангийн 2, ААТҮГ-ийн 2 / *Баянгол сувилал, Баянгол хөгжлийн гүүр* /, нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЕБС, цэцэрлэгийн санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, 4 байгууллага, 2 төсөл сан, 2 ААТҮГ-ын тайланг аудитын түүвэрт хамруулсан байна.

Эдгээрээс “Баянгол хөгжлийн гүүр” ААТҮГ нь 2021 онд үйл ажиллагаа явуулаагүй болно.

Баянгол сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 417,980.0 мянган төгрөгийн 13 алдаа, зөрчил илрүүлснээс 13,283.1 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 9,210.0 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 395,486.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг хүргүүлээ.

Аудитад хамрагдсан харьяа 2 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 200,013.1 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илрүүлснээс 13,283.1 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 6,210.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 180,520.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмжийг хүргүүлээ.

4.1 Залруулга:

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тайлагналын алдаатай **13,283.1** мянган төгрөгийн залруулгыг санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

ЭМТ:

- Үндсэн хөрөнгөд 13,283.1 мянган төгрөгийн элэгдэл зөрүүтэй тайлагнасан,

4.2 Албан шаардлага:

1. Баянгол сувилал” ААТҮГ нь харилцах дансаар 19,107.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 18,799.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн боловч санхүүгийн тайланд орлого, зарлагыг тус бүр **6,210.0** мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ*”, 14.4.5: “*бүх орлого*”, 14.6: “*бүх зардал*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлого, зардлыг бүртгэл тайланд үнэн зөв тусгаж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэх.

4.3 Зөвлөмж:

4.3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс дараах байгууллагууд хөтөлбөр болон зардлын бүлэг хооронд нийт **6,872.8** мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан зөрчил гаргасан байна. Үүнд:

Иргэдийн төлөөлөгчийн хурал:

- Үндсэн цалингаас БИНХ-ын урамшууллын зардалд 797.1 мянган төгрөг,

Засаг даргын Тамгын газар:

- Үндсэн үйл ажиллагааны НДШ-ийн зардлаас баг хорооны НДШ-ийн зардалд 1,165.7 мянган төгрөг,

Эрүүл мэндийн төв:

- НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 4,910.0 мянган төгрөг,

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчиж байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлж байх.

4.3.2 Анхан шатны болон цахим төлбөрийн баримттай холбоотой асуудал:

2.1 Илрүүлэлт: Тайлант онд ИТХ нь 18,811.4 мянган төгрөгийн, ЗДТГ нь 5,140.2 мянган төгрөгийн, Соёлын төв нь 1,592.2 мянган төгрөгийн, ЭМТ нь 132,127.2 мянган төгрөгийн зэрэг нийт **157,671.0** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан “загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна

2.2 Өгсөн зөвлөмж: Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

4.3.3 Зардлын данстай холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт: Жилийн эцэст НДШ-ийн тооцоог холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж өр төлбөр, авлагагүйгээр баталгаажуулсан хэдий ч ЗДТГ-ын НДШ-ийн тайланд 4 албан хаагчийн цалинг 1,186.7 мянган төгрөгөөр дутуу, 2 албан хаагчийн 884.6 цалинг мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь НДШ-ийн авлага, өр төлбөр үүсгэх эрсдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчиж байна.

3.2 Өгсөн зөвлөмж: 2022 оны 2-р улиралд багтаан холбогдох байгууллагуудтай дахин тооцоо нийлж, тулган баталгаажуулах.

4.3.4 Мөнгөн кассын ажиллагааны журамтай холбоотой асуудал:

4.1 Илрүүлэлт: ЭМТ нь Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын **15,977.0** мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр тушаасан байна. Энэ нь “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.12 дэх “Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд **ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана**” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Цаашид тухай бүр өөрийн орлогыг харилцах дансанд тушааж, мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөн ажиллах.

4.3.5 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал:

5.1 Илрүүлэлт: ЭМТ-ийн 2019-2020 онуудад орлого авсан 60 нэр төрлийн үндсэн хөрөнгөд элэгдэл тооцож зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”, 14.4.6 “бүх зардал”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.35 дах “Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

5.2 Өгсөн зөвлөмж: 2022 оны 2-р улиралд багтаан үндсэн хөрөнгийн элэгдлийг нөхөн тооцох.

4.3.6 Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал:

6.1 Илрүүлэлт: “Баянгол сувилал” ААТҮГ нь нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, стандартад заасан дарааллаар хөтлөөгүй, ш ажил гүйлгээнүүд нь анхан шатны баримт болон журналын бичилтээр бүрэн нотлогдохгүй, аудитын явцад шаардлагатай баримт материалыг бүрэн гүйцэт ирүүлээгүй буюу аудит хийж гүйцэтгэх нөхцөл боломжоор хангаагүй учир санхүүгийн тайланд тусгагдсан ажил

гүйлгээнүүд нь хууль эрхийн актад нийцэж, үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг батлах боломжгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 14 дүгээр зүйлийн 14.3, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “ Нийцсэн бөгөөд зохистой байх “ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6.2 Өгсөн зөвлөмж: ТТЗ-ийн зүгээс тус үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлж, шалгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
						Залруулга		Төлбөрийн акт		Хариуцлага тооцуулах		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал															
1	ТТЗ	СЭА-2022/03-НА-СТА-ТТЗ	Үндсэн хөрөнгийн элэгдлийг зөрүүтэй тайлагнасан,	1	13,283.1	1	13,283.1								
2	ТТЗ	СЭА-2022/03-НА-СТА-ТТЗ	“Баянгол сувилал” ААТҮГ- нь санхүүгийн тайланд орлого зарлагыг дутуу илэрхийлсэн	1	6.210.0							1	6.210.0		
3	ТТЗ	СЭА-2022/03-НА-СТА-ТТЗ	Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс хөтөлбөр болон зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан,	1	6,872.8									1	6,872.8
4	ТТЗ	СЭА-2022/03-НА-СТА-ТТЗ	Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй,	1	157,671.0									1	157,671.0
5	ТТЗ	СЭА-2022/03-НА-СТА-ТТЗ	Жилийн эцэст НДШ-ийн тооцоог холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж өр төлбөр, авлагагүйгээр баталгаажуулсан хэдий ч ЗДТГ-ын НДШ-ийн тайланд 6 албан хаагчийн цалинг илүү, дутуу тайлагнасан,	1	-									1	-
6	ТТЗ	СЭА-2022/03-НА-СТА-ТТЗ 3	ЭМТ нь Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр тушаасан байна.	1	15,977.0									1	15,977.0

7	ТТЗ	СЭА-2022/03-НА-СТА-ТТЗ	ЭМТ-ийн хөрөнгөд бүртгэлтэй 60 нэр төрлийн үндсэн хөрөнгөд элэгдэл тооцож зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнаагүй байна	1	-								1	-		
8	ТТЗ	СЭА-2022/03-НА-СТА-ТТЗ	“Баянгол сувилал” ААТҮГ-ын санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээнүүд нь хууль эрхийн актад нийцэж, үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг батлах боломжгүй байна.	1	-								1	-		
Дүн				8	200,013.9	1	13,283.1					1	6,210.0	6	180,520.8	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	ТТЗ	СЭА-2022/03-НА-СТА-ТТЗ	ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчиж батлагдсан төсвийг 10-аас доош хувиар хэмнээгүй,	1	-								1	-		
2	ТТЗ	СЭА-2022/03-НА-СТА-ТТЗ	ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-дүгээр заалтыг зөрчсөн,	1	3,000.0								1	3,000.0		
3	ТТЗ	СЭА-2022/03-НА-СТА-ТТЗ	Харьяа байгууллагууд шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн болон шилэн дансны цахим санд хаяг нээлгээгүй.	1	-								1	-		
Дүн				3	3,000.0								3	3,000.0		
Нийт дүн				11	203,013.9	1	13,283.1						4	9,210.0	6	180,520.8